



Монгол улсын эдийн засгийн тойм 2010 оны 3-р сар Дэлхийн Банк



Дэлхийн Банкнаас сар бүр эрхлэн гаргадаг *Монгол улсын эдийн засгийн тойм* нь эдийн засаг, нийгмийн хөгжил, бодлогуудын талаархи хамгийн сүүлийн үеийн мэдээллийг багтаадаг юм. Мөн Дэлхийн Банкны Монгол улсад явуулж байгаа үйл ажиллагааны үр дүнг танилцуулдаг. *Сар бүрийн тоймыг* боловсруулахад Дэлхийн Банкны Зүүн Ази Номхон далайн бүсийн Дэд Ерөнхийлөгчийн дэргэдэх Ядуурлыг Бууруулах, Эдийн засгийг удирдах (ЯБЭЗУ) салбар нэгжийн мэргэжилтнүүдээс гадна Монгол улсы хариуцсан ажлын хэсгийн бусад гишүүд хувь нэмэр оруулсан болно. Сарын тоймтой холбоотой ссуулт, санал хүсэлт байвал Шийлэгмаагийн Алтанцэцэгт (ashiilegmaa@worldbank.org) хандана уу. БАримт бичгийн хувийг <http://www.worldbank.org.mn> хаягаар орж татаж авч болно.

Агуулга

Товч дүгнэлт	4
Төсвийн хөгжил	5
Гадаад салбар	9
Инфляци	12
Банкны салбар	13
Хөдөлмөрийн зах зээл, ядуурал	18
УИХ-ын хаврын чуулганаар хийгдэх шинэчлэлүүд	19

Зураг

Зураг 1 Төсвийн алдагдал сайжрах хандлага 2010 оны 1-р улиралд зогссон	6
Зураг 2 2010 оны 1-р улиралд зарлага, ялангуяа цэвэр зээл, татаас, нийгмийн халамжийн мөнгөний зарцуулалт огцом өссөн	6
Зураг 3: Цалингийн ангиллын дагуу улсын болон хувийн хэвшилд сард дунджаар бэлэн мөнгөөр олгож байгаа нийт цалин	Error! Bookmark not defined.
Зураг 4 Худалдааны алдагдал тогтворжиж, 2009 онтой харьцуулбал сайжирсан	10
Зураг 5 Ашигт малтмалын үнийн өсөлт үргэлжилж байгаа	10
Зураг 6 Ерөнхий суурь сайжирч байгааг үл харгалзан БНХАУ-аас оруулж ирэх импорт өсөж байна	10
Зураг 7 ...Монгол улсын экспортыг дэмжиж байна	10
Зураг 8 Нүүрс, зэсийн экспорт сайн гүйцэтгэлтэй байна	11
Зураг 9 Импорттой хамт өсөлт 2010 онд ч үргэлжилж байна	11
Зураг 10 Валютын ханш тогтвортой байна	12
Зураг 11 Монгол банкны гадаад валютын нөөц рекорд тогтоох түвшинд хүрээд байна	12
Зураг 12 Сүүлийн хэдэн сард инфляцийн дарамт ихэссээр байна	13
Зураг 13 Жилийн инфляцийн түвшин бас нэмэгдсэн	13
Зураг 14 Гэхдээ зээлийн нэрлэсэн хүү тогтвортой байна	14
Зураг 15 Төгрөгийн хадгаламж нэмэгдэж, гадаад валютын хадгаламж цаашид буурах хандлагатай байна	14
Зураг 16 Нийт зээлийн өсөлт нэмэгдэхгүй байгаа ч Монгол банкнаас гаргасан үнэт цаасны худалдан авалт нэмэгдсээр байна	15
Зураг 17 Чанаргүй зээлийн харьцаа 20 хувиас дээш үзүүлэлттэй байна	15
Зураг 18 Ажилгүй бүртгэлтэй иргэдийн тоо* сүүлийн саруудад буурсан	18

Хүснэгт

Хүснэгт 1: Улсын хэмжээний хатуу хучилттай замын сүлжээний нөхцөл байдал.....	7
Хүснэгт 2 Монгол улсын гол үзүүлэлтүүд.....	21

Хайрцаг

Хайрцаг 1 Автозамын салбарын кейс стади буюу жишээ дасгалаар олж авсан мэдээлэл..	7
Хайрцаг 2 Сайн гүйцэтгэлтэй Төрийн албатай болохын төлөө	8
Хайрцаг 3 Турк: 2000/2001 оны хямралын дараахь банкны салбарын шинэчлэл	16
Хайрцаг 4 Малчинд олгох зээл нь чанартай зээл юм.....	18

Товчилсон үгс

bn	Тэрбум
BoM	Монголбанк
CPI	Хэрэглээний үнийн индекс
FX	Гадаад валют
GDP	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
LC	төгрөг
LHS	Зүүн гар талд
MFA	Монгол улсын санхүүгийн холбоо
mn	сая
MNT	Төгрөг
MoF	Сангийн яам
mom	Өмнөх сартай харьцуулбал
mt	тонн
NPL	Чанаргүй зээл
NSO	Үндэсний Статистикийн Газар
RHS	Баруун гар талд
USD	Ам. доллар
WPT	Гэнэтийн ашгийн татвар
yoY	Өмнөх жилтэй харьцуулбал
ytd	Оны эхнээс өнөөдрийг хүртэл

2010 оны 1-р улиралд төсвийн зардал тэлсэн нь өсч буй орлогын нөлөөг бууруулж сайжрах хандлагатай байсан төсвийн алдагдал зогсонги байдалтай болов. Хэрэв зардал уул уурхайн орлоготой зэрэгцэн өссөөр байвал Монгол Улс эргээд хямралын өмнөх жилүүдийн мөчлөг дагасан эрсдэл рүү очих аюултай байна. Гэсэн хэдий ч ирэх хэдэн жилүүдэд санхүүжилтын нөхцлүүд хүндхэн төсөөлөгдөж байгаа тул төсвийг үргэлжлүүлэн бэхжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, 2011 онд гэнэтийн ашгийн татвар хүчингүй болсоноор төсвийн хувьд хүндрэлтэй жил байх болно.

Үүнээс үүдэн гарах бэрхшээл нь Монгол Улс дэд бүтцийн асуудлаа төсвийн боломжит хүрээнд шийдвэрлэхэд одоогийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлуудаа яаж удирдах вэ гэдэгт байна. Одоогийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон гүйцэтгэлийн явц хэд хэдэн сул талуудаас болж доройтож байгааг Хайрцаг 1-т замын салбарын хөрөнгө оруулалтын жишээгээр шинжлэв. Мөн төсвийн томоохон зардлуудын нэг болох цалингийн хэмжээ нэмэгдэх дарамттай тулгараад байна. Хайрцаг 2-т төрийн албаны цалингийн өсөлтийн түвшинг тодорхойлсон хамгийн сүүлийн үед хийсэн судалгааны урьдчилсан дүнг харуулав. Төрийн албан хаагчдын өндөр түвшинд олгодог нийт мөнгөн урамшуулал нь адил түвшин дэх хувийн хэвшлийн ажиллагсадтай харьцуулахад ойролцоогоор 60-70 хувьтай байна. Гэвч, цалин, тэтгэмж болон хангамжийг ажлын тогтвортой байдалтай хамтад нь харьцуулж үзэхэд цалин, тэтгэмж зохистой түвшинд байна. Түүнчлэн төрийн албаны доод шатны ажилтнуудын авах нийт мөнгөн урамшуулал нь хувийн хэвшлийнхтэй харьцуулахад ижил эсвэл илүү түвшинд байна.

Монгол Улсын худалдааны алдагдал ойрын саруудад 12 сарын гулсмал нийлбэрээр авч үзэхэд тогтвортой байна. Монгол Улсын экспорт ашигт малтмалын үнийн өсөлт болон Монгол Улсын худалдааны хамгийн том түнш болох Хятад улс руу импортлох импортын хэмжээ өссөнөөр дэмжигдэн тогтвортой сэргэж байна. Ам.долларын эсрэг валютын ханш тогтворжиж, гадаад валютын нөөц өндөр хэвээр байна.

Эдийн засгийн сэргэлт болон 2010 оны эдийн засгийн өндөр өсөлтийн төсөөлөл сүүлийн үед үнэ өсөхөд нөлөөлж байна. Эдийн засгийн сэргэлтийн үед үнийн өсөлтийн дарамт үүсч магадгүй байгаа ч энэ хандлагыг цаашид өмнөх өсөлттэй үеүүдэд ажиглагдсан хэт халалт руу хөөргөхгүй байхыг баталгаажуулах нь чухал юм.

Банкны салбарт нийт зээлийн өсөлт зогсонги байдалтай, зээл болон хадгаламжийн нэрлэсэн хүүгийн хэмжээ өндөр хэвээр байна. 2009 онд нийтдээ 143.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан арилжааны банкууд 3-р сард 2.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Хугацаа хэтэрсэн үндсэн өрийн төлбөрийн хэмжээ өсч нийт зээлийн хэмжээтэй харьцуулсан чанаргүй зээлийн багц 3-р сард тогтвортой байгаа хэдий ч 22 хувьтай өндөр хэвээр байна. Монгол банк олон улсын туршлагаудаас (үүнд Хайрцаг 3-т үзүүлсэн 2000/2001 оны Туркын банкны салбарын хямралаас гарсан туршлагыг тоймлов) тусгасан банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг саяхан боловсруулсан. УИХ энэхүү төлөвлөгөөг цаг алдалгүй батлах нь Монгол Улсыг бүтцийн өөрчлөлт болон засгийн газрын дэмжлэгтэй холбогдон гаргах эдийн засгийн болон төсвийн зардлыг хязгаарлах олон улсын шилдэг туршлагад нийцүүлсэн арга хэмжээ авахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

¹ Энэхүү дүн шинжилгээг Сангийн Яам, Үндэсний Татварын Ерөнхий Газар, Үндэсний Статистикийн Газар, Монголбанк (банкны системийн нэгдсэн баланс ба сар бүрийн тойм)-ны хамгийн сүүлийн үе (2009 оны 2-р сар)-ийн мэдээлэл дээр үндэслэж хийсэн болно..

Бодит салбарт Монгол Улсын нутаг дэвсгэрийн 80 гаруй хувийг хамарч, учруулсан хохирлын хувьд урд жилүүдийнхээс илүү давсан өнгөрсөн өвлийн зудын гамшиг банк болон чухал салбаруудад нөлөөлхөөр байна. Саяхныг болтол малчдын зээл харьцангуй сайн эргэн төлөлттэй байсан бол (4-р хайрцаг) зүй бусаар хорогдсон малын тоо 7 саяд (нийт малын 15.6 хувь) хүрч байгаа нь чанаргүй зээлийн өсөлтөнд нөлөөлөх магадлалтай болоод байна.

Одоогоор Монгол Улсын Парламент хэд хэдэн чухал шинэчлэлүүдийг хэлэлцэж байгаа бөгөөд үүнд төсвийн тогтвортой байдлын тухай болон нэгдсэн төсвийн тухай хуулиуд нь уул уурхайн орлогыг зөв удирдах болон тууштай төсвийн бодлогын хүрээг тавих болно. Бодлогын хүрээн дэх гол чиглэлүүдийг сайжруулах эдгээр чухал алхамууд нь Монгол Улсыг гэнэтийн өсөлт-бууралтын мөчлөгөөс сэргийлэхэд тусалж, цаашдын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих болно.

Төсвийн хөгжил

2010 оны 1-р улиралд төсвийн зардал тэлсэн нь өсч буй орлогын нөлөөг бууруулж сайжрах хандлагатай байсан төсвийн алдагдал зогсонги байдалтай болов.

2009 оны 4-р улиралд эрчтэй сайжирсны дараа сүүлийн хэдэн сарын төсвийн тэнцэл тогтвортой байсан. Орлогын гүйцэтгэл сайжирч байсан ч зарлага төдий чинээгээр нэмэгдсээр байна. Хэрэв зардал орлоготой зэрэгцэн өссөөр байвал Монгол Улс эргээд хямралын өмнөх жилүүдийн мөчлөг дагасан эрсдэл рүү очих аюултай байна.

Хэдийгээр орлого нэмэгдэж байгаа ч энэ оны 3 дугаар сард 12 сарын гулсмал байдлаар алдагдал ДНБ-ны 5.2 хувийг эзлэх болсон. 12 сарын гулсмал нийлбэрээр нийт орлого ДНБ-ны 34.7 хувь, нийт зарлага, цэвэр зээл ДНБ-ны 39.9 хувийг эзэлж байна (Зураг 1).


2009 оны 9 дүгээр сараас хойш орлогын гүйцэтгэл мэдэгдэхүйц сайжирсан. Тухайлбал 2010 оны 3 дугаар сард нийт орлогын өсөлт, буцалтгүй тусламж нь нэрлэсэн хугацаанд 66 хувь, бодит хугацаанд 61 хувьд хүрсэн байсан. Эдийн засгийн бодит үйл ажиллагаа, импорт болон ашигт малтмалын үнэ, жилийн өсөлтийг 3 дугаар сарын компанийн орлогын албан татвар (өмнөх жилтэй харьцуулбал 92 %-иар өссөн), гэнэтийн ашгийн татвар (12 дахин өссөн), НӨАТ (63 хувиар өссөн), гаалийн татвар (39 хувиар өссөн), нөөц ашигласны төлбөр (хоёр дахин өссөн) зэргээс харж болно.

Гэвч сүүлийн хэдэн сард зардал нэмэгдэж, өмнөх жилтэй харьцуулбал 50 хувиар өссөн байна. Хямралын үеийн зарлагын хязгаарлалтаас болж 2009 оны эхээр бага байсан суурь үзүүлэлтийн зарим нь өсөх хандлагатай байна. Энэхүү хандлага цаашид өсвөл төсвийн нэгтгэл хийх явцад сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Зарлагын нэг гол үзүүлэлт бол 87.6 тэрбум төгрөгийг ХХС-аас хуваарилж, бэлнээр тарааж байгаа явдал байсан бол эрчим хүч, нийтийн тээврийн салбарт олгох татаас нь 2009 оны 3 дугаар сарын үзүүлэлттэй харьцуулбал 3 дахин өссөн байна. Зээлийн хүүгийн төлбөр мөн өсөж, 2009 оны алдагдлыг өрөөр санхүүжүүлэх явдлыг нэмэгдүүлж байна. Дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа ч эхний улиралд дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх ажил төлөвлөгөөтэй харьцуулбал дөнгөж 30 хувьтай байна. Энэ нь шийдвэр гаргах, тендер шалгаруулах ажлыг цаг хугацаанд нь үр ашигтай хийх явдлыг нэмэгдүүлэхийн тулд хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Ялангуяа банкны салбарт нүүрлээд байгаа асуудлыг шийдвэрлэхэд гарах зардалтай холбоотой цэвэр зээл олголт огцом өссөн байна. Эхний улиралд 110 тэрбум төгрөгийн цэвэр зээл олгосон нь 2009 онд олгосон 72 тэрбум төгрөг, 2010 онд олгохоор төлөвлөсөн

99 тэрбум төгрөгөөс хэдийнэ илүү гарсан үзүүлэлттэй байна. Олгосон зээлийн ихэнх буюу 100 тэрбум төгрөг нь Төрийн банкинд засгийн газрын оруулах хөрөнгийн баталгаа болгон байршуулах засгийн газрын үнэт цаас хэлбэрээр төв банкинд олгосон зээл байсан. Мөн 4000 айлын орон сууц хөтөлбөр, төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийг санхүүжүүлэхийн тулд 6 тэрбум төгрөгийн зээлийг Орон Сууцны Санхүүжилтийн Корпораци (ОССК)-д олгосон байна.

Зураг 1 Төсвийн алдагдал сайжрах хандлага 2010 оны 1-р улиралд зогссон



Тайлбар: *ДНБ нь 2008, 2009 оны бодит ДНБ-ний мэдээлэл, 2010 оны төсөөлөл мэдээллийг агуулсан болно.


** Тодотгосон төсвийн тэнцэл нь зарлагаас цэвэр зээлийг хасаж, зөвхөн урсгал болон капитал зардлыг оруулсан болно.

Эх сурвалж: Сангийн яам, Дэлхийн Банкны ажилтнуудын хийсэн тооцоо.

Ирэх хэдэн жилийн төсөөллөөс харвал санхүүгийн энэхүү хүнд нөхцөлд зарлагыг хязгаарлах хэрэгтэй байна. Ялангуяа гэнэтийн ашгийн татвар үгүй болж, төсвийн дэмжлэг болгон өгдөг хандивлагчдын санхүүжилтийн хэмжээ багасахтай холбоотойгоор 2011 он төсвийн хувьд хүнд жил байхаар байна. Үүнээс үүдэн гарах бэрхшээл нь Монгол Улс дэд бүтцийн асуудлаа төсвийн боломжит хүрээнд шийдвэрлэхэд одоогийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлуудаа яаж удирдах вэ гэдэгт байна. Олон жижиг хөрөнгө оруулалтын төслүүдээс ялангуяа Оюу Толгой төслөөс цаашдын өсөлт ихээхэн хамаарах учраас энэ нь их чухал асуудал юм. Тиймээс ОТ уурхайн бүтээн байгуулалт, холбогдох дэд бүтцийг бий болгох ажлыг цаг алдалгүй эхлүүлэх шаардлагатай байна. Одоогийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон гүйцэтгэлийн явц хэд хэдэн сул талуудаас болж доройтож байгааг Хайрцаг 1-т замын салбарын хөрөнгө оруулалтын жишээгээр шинжлэв.

Зураг 2. 2010 оны 1-р улиралд зарлага, ялангуяа цэвэр зээл, татаас, нийгмийн халамжийн мөнгөний зарцуулалт огцом өссөн

Өмнөх оны мөн үетэй харьцуулсан хуримтлагдсан орлого %



Тайлбар: Энэхүү өсөлт нь графикийн хэмжээнд тусгалаа олоогүй байгааг энэхүү хайрцагт байгаа тоо харуулж байна

Эх сурвалж: Сангийн яам, Дэлхийн Банк

Хайрцаг 1 Автозамын салбарын кейс стади буюу жишээ дасгалаар олж авсан мэдээлэл

Дэлхийн Банк нь Монгол улсын замын сүлжээний одоогийн нөхцөл байдлыг судлах, төслүүдийн үргэлжлэх хугацааны сул холбоосуудыг олж тодорхойлохын тулд дуусаагүй байгаа болон саяхан хэрэгжиж дууссан 10 төслийг сонгон авч үзсэн. Судалгаанаас харвал Монгол улсын автозамын салбарт зам засварын хийгдэж дуусаагүй ажил их байгаагийн зэрэгцээ хатуу хучилттай замын 60 гаруй хувь нь муу замууд байна. Түүнчлэн салбарын хөрөнгө оруулалтын шинэ төслүүдийн төлөвлөлтийн хүрээ сул, замын ажлыг дуусгах хугацаа дунджаар 2.3 жил (буюу 180 хувь)-ээр хэтэрсэн байна

Хүснэгт 1: Улсын хатуу хучилттай автозамын сүлжээний нөхцөл байдал

Нөхцөл	км	Нийт ангилсан замд эзлэх хувь (%)
сайн	864.4	17
боломжийн	1,209.6	24
муу	2,925.9	59
Нийт	4,999.9	100

Эх сурвалж: Автозамын газар.

2005 оноос хойш хэрэгжүүлсэн нийт 50 гаруй төслөөс улсын төсвөөс санхүүждэг 10 замын жишээг авч судалсан. Судалгаанд хамрагдсан төслүүдийн аль нь ч төлөвлөлтийн аль ч үе шатанд зардал/үр ашгийн дүн шинжилгээ хийгдээгүй байсан. Үүний гол шалтгаан нь эдийн засгийн дүн шинжилгээ хийх үр чадвар төрийн албан хаагчид, төслийг хэрэгжүүлэгчдийн аль алинд дутагдалтай байсанд оршино. Албаны хүмүүсийн хэлснээр хөдөө орон нутагт хүн амын нягтрал бага учраас зам ашиглалтын судалгааг хийхэд замын урсгалын үзүүлэлт хангалтгүй байдаг. Монгол улсад эдийн засгийн дүн шинжилгээнээс илүүтэйгээр төслийн нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл хамааралтай байдаг. Замын хөдөлгөөн хангалтгүй байгаа нь хямд бус өртгөөр шинэ зам барихад хүргэдэг ч шинээр барьж байгаа хатуу хучилттай замууд нь малын бэлчээрийг хамгаалж (шороон замаар жолоодохыг болиулах) байдаг төдийгүй тухайн бүс нутгийн дэд бүтцийг сайжруулж, нэмэгдүүлж байдаг. Ач холбогдлоор нь ангилж ангиллыг хийдэг боловч нийт багцийн 54 хувь нь нэн тэргүүний, 38 хувь нь дунд зэргийн 8 хувь онцын яаралгүй барих замууд байна.

Мөн техник эдийн засгийн үндэслэл хангалтгүй байдгаас төслүүдийг техникийн бичиг баримтгүйгээр шууд гэрээлэх замаар хэрэгжүүлэх эрхийг олгодог. Судалгаанд хамрагдсан 10 төслийн дөрвийг шууд гэрээгээр, үлдсэнийг тендерээр хэрэгжүүлсэн. Эхнийх нь гэрээнүүдийг байгуулахаас өмнө зохих шалгууруудаар оруулж шалгаж үзэлгүйгээр гэрээг байгуулсан төслүүд байсан. Газар дээр нь очиж техник технологитой танилцаагүйн улмаас өндөр өртөгтэй инженерингийн интервенц хийх, ажлын хүрээг нэмэгдүүлэхэд хүргэж байсан. Арван төслийн долоо нь хүлээлгэн өгөх хугацаа хэтэрсэн. Төслийг хэрэгжүүлж дуусгах хугацаа 1,8 жил гэж төлөвлөж байсан бол дунджаар 3.1 жилд дуусгаж (70 хувийн хугацаа хэтэрсэн бол шууд гэрээлсэн төслүүд нь дунджаар 2.3 жил (буюу 180 хувь)-ээр хугацаа хэтэрсэн байсан.

Автозамын багцийн хувьд хугацаа хэтэрсэн (зарим тохиолдолд төлөвлөсөн хугацаанаас 2 дахин урт хугацаатай байсан) гүйцэтгэлтэй төслүүд нь төлөвлөлт муу, зардлын тооцоог нарийн гүйцэд гаргаагүй, төлбөрийн асуудал болон барилгын салбарын сул талууд гэсэн хүчин зүйлүүдээс болсон байна. УИХ-аас нэмсэн төслүүдийн хувьд инженерингийн зураг төсөв байдаггүй учраас санхүүжилт нь байнга удааширдаг. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд 2010 оны төсвийг гаргахдаа барилгын компаниудын барих шинэ замуудыг эргэн төлөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлэх багцуулыг төсөвт суулгаж өгсөн.

Тайлбар: энэхүү судалгааны үр дүн нь Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт гэсэн бодлогын баримт бичгийг гаргахад үндсэн дүн шинжилгээ болж өгсөн, 2010 оын 3-р сар, Дэлхийн Банкны Зүүн Ази Номхон далайн бүсийн Дэд Ерөнхийлөгчийн дэргэдэх Ядуурлыг Бууруулах, Эдийн засгийг удирдах (ЯБЭЗУ) салбар нэгж, Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам, АвтоЗамын газар.

Цалин хөлс нь төсөв дотор зарлагын томоохон хэмжээг эзэлдэг зүйл төдийгүй үнийн огцом өсөлттэй үед ихээхэн нэмэгддэг, 2007 онд урсгал зардал 20 хувийн өсөлттэй байсан бол 2008, 2009 онд 30 хувь болж нэмэгдсэн. Саяхан гурван талт хэлэлцээрийн дүнд 2010 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн тэтгэвэр, төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмэгдүүлэхээр тохиролцсон. Улсын салбарын цалингийн өсөлтийг тодорхойлохдоо хувийн хэвшлийн цалинтай харьцуулах асуудал байсан (үнэндээ Төрийн Албаны Зөвлөл нь хуулиар энэхүү харьцуулсан судалгааг жил бүр хийх үүрэгтэй). Хайрцаг 2-т хамгийн сүүлд хийсэн судалгааны дэлгэрэнгүйг урьдчилсан байдлаар үзүүлэв.

Хайрцаг 2 Сайн гүйцэтгэлтэй Төрийн Албаны Зөвлөлтэй байхын төлөө

- Төрийн Албаны Зөвлөлийн тухай хуулиар Төрийн Албаны Зөвлөл нь Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Үндэсний Статистикийн Газартай хамтран жил бүр төрийн албан хаагчдын цалингийн судалгааг хийх ёстой гэж заасан байдаг. Ийнхүү хамгийн анхны судалгааг Дэлхийн банкны техникийн туслалцаатайгаар хийсэн бөгөөд үр дүнг дор мэдээллээ.
- **Судалгааны арга зүй** нь дараахь алхмуудаас бүрдсэн. Үүнд:
- **1-р алхам:** Хувийн хэвшлийнхтэй харьцуулж болох төрийн албаны ажлын байруудыг тодорхойлох. Ийнхүү харьцуулалт хийх зорилгоор 50 ажлын байрыг сонгосон. Эдгээр сонгосон ажлын байрууд нь төрийн албаны дэд салбаруудыг төлөөлөх ба яамдын дээд түвшний захиргааны ажлын байрууд, яамдуудын Үндэсний Статистикийн Газар, Их сургуулиуд, засгийн газрын байгууллагуудын мэргэжлийн ажлын байрууд, багш, эмнэлгийн ажилтнууд гэх мэт үйлчилгээний ажилтнуудаас бүрдэж байсан. Ижил төрлийн ажлын байрнуудын харьцуулалтыг хийх зорилгоор мөн ажлын байр тус бүрийн ур чадвар, асуудлыг шийдэх, шийдвэр гаргах, нөөцийг удирдах гэх мэт холбогдох хүчин зүйлсийг хэмжихийн тулд ажлын байрнуудын үнэлгээг хийсэн. Үүний үр дүнд ажлын байр тус бүрийг онооны системээр үнэлсэн төдийгүй улсын болон хувийн салбарын ижил төрлийн ажлын байрнуудын цалингийн харьцуулалтыг хийх боломжтой болсон.
- **2-р алхам:** Судалгааг хийх цаг хугацааг сонгох. Судалгааг зөвхөн Улаанбаатар хотод хийсэн бөгөөд үйлдвэр үйлчилгээний 9 газар, ерөнхий боловсролын болон дээд боловсролын 7 сургууль, санхүүгийн 3 байгууллага, 3 томоохон эмнэлэг хамрагдсан.
- **3-р алхам:** Цалингийн судалгаа. Цалингийн асуулгыг явуулж, сонгосон хувийн болон улсын салбарын ажлын байруудын нийт цалин (үндсэн цалин тэтгэмж)-гийн тухай мэдээллийг олж авсан. Энэхүү ажлыг хөнгөвчлөхийн тулд төрийн албаны ажлын байруудыг цалингийн 14 зэрэглэлд оруулж, ангилал тус бүр нь төрийн албаны ижил түвшний цалинтай ажлын байруудыг багтааж байсан. Энэхүү ангиллын цалинг хувийн хэвшлийн ижил ажлын байруудын цалинтай харьцуулсан.
- **Судалгааны үр дүнг** Зураг 3-т үзүүлсэн ба үүнд ангилал тус бүрийн сарын нийт бэлэн мөнгөөр авдаг цалингийн дундаж (мянган төгрөг)-ийг үзүүлээ. Үр дүнгээс харвал:
- Дээд ахлах албан тушаалын түвшинд, төрийн албаны нийт цалин нь хувийн салбарынхтай харьцуулахад 60-70 хувьд байсан. Хэдийгээр цалингийн хувьд их ялгаатай байгаа ч ашиг болон ажлын байрны аюулгүй байдал (ажилтай байх)-тай харьцуулж үзэхэд цалин, ашиг нь тийм ч таатай бус байна. Бусад орнуудад эдгээрийн зөрүү нь 100 хувь эсвэл 200 хувьтай байдаг байна.
- Төрийн албаны доод түвшний албан тушаалууд нь хувийн хэвшилтэй харьцуулбал ижил буюу илүү цалин авч байсан.
- Цалинг бууруулах үзэгдэл хувийн хэвшлээс илүү улсын салбарт ажиглагдаж байсан (доод албан тушаалаас дээш дэвшихэд цалин харьцангуй бага нэмэгддэг г.м) нь төрийн албанд ажиллах, татагдах байдалд нөлөө үзүүлдэг

- **Зураг 3: Цалингийн ангиллын дагуу улсын болон хувийн хэвшилд сард дунджаар бэлэн мөнгөөр олгож байгаа нийт цалин**



- Тайлбар: бага цалин нь өндөр албан тушаалыг илтгэнэ.
- Эх сурвалж: Төрийн Албаны Зөвлөл.
- **Бодлогын хувьд**
- СУдалгаанаас үзвэл бага зэрэглэлийн албан тушаалууд буюу төрийн албаны ихэнх хэсгийг бүрдүүлдэг ажлын байрнуудын хувьд цалин нэмэх шаардлагагүй, учир нь тэдэнд цалинг дутуу олгодоггүй. Харин өндөр албан тушаалын төрийн албаны ажилтнуудын хувьд цалинг хувийн хэвшлийн цалингийн 80 хувьтай тэнцэх хэмжээний (төрийн албанд ажиллуулах, ажлын байранд байлгахын тулд) өсгөх шаардлагатай байгаа бөгөөд үүнийг хэд хэдэн үе шаттайгаар хэдэн жилийн турш нэмж болно.
- Эх сурвалж: Төрийн Албаны Зөвлөлийн судалгааны үр дүнд үндэслэж Дэлхийн Банкны гаргасан дүгнэлт

Гадаад салбар

Монгол улсын экспортын салбар ашигт малтмалын үнийн өсөлтийг даган сэргэж байна


Сүүлийн саруудад худалдааны алдагдал 12 сарын гулсмал нийлбэрээр тогтвортой байна. Энэхүү алдагдал 2009 оны 3-р сард 1082 сая ам.доллар байсан бол 2010 оны 3-р сард 235 сая ам.доллар болж сайжирсан байна (Зураг 4). Ийнхүү Монгол улсын экспортын салбар тогтворжиж байгаа нь металлын үнийн өсөлт (Зураг 5), Монгол улсын худалдааны томоохон түнш БНХАУ-аас оруулж ирэх импортын өсөлт (Зураг 6)-тэй холбоотой юм. Мөн Монгол улсын худалдааны үзүүлэлтээс харвал БНХАУ руу гаргаж байгаа нүүрс, зэсийн экспортын өсөлттэй холбоотойгоор БНХАУ руу хийх экспорт нэмэгдэж байна (Зураг 7). 2010 оны 3-р сард зэсийн үнэ өссөн хэвээр байгаа бөгөөд 2008 оны дунд үеэс эхлэн ашигт малтмалын үнэ буурснаас хойш анх удаагаа зэсийн үнэ хамгийн дээд дундаж үнэд хүрсэн (7463 ам.доллар/тонн) байна. Гэвч зэсийн үнэ суурь үнэтэй харьцуулбал хэт хөөрөгдсөн байгаа бөгөөд зөвхөн худалдаж аваад буцаад зарж байгаа биржийн тоглолт нь үнийг хөөргөөд байна гэж шинжээчид үзэж байгаа юм.

Импортын бүтцийн хувьд нүүрсний экспортын өсөлт их чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд зөвхөн 3-р сард жилийн өсөлтийн 1/3 хувийг эзэлж байна. Энэ нь жижиг, дунд компаниуд БНХАУ руу нүүрс экспортлож байгаатай холбоотой. Боолвсруулаагүй

нүүрсний үнэ бага байгаатай холбоотойгоор БНХАУ-ын нүүрс худалдан авагчдын эрэлт нэмэгдсэн. Зэсийн экспортын жилийн өсөлт нийт экспортод эзлэх хувь харьцангуй багассан. Тиймээс БНХАУ-д хийгдэх бүтээн байгуулалтын ажил нь манай улсын экспортод их чухал ач холбогдолтой байдаг. Учир нь Монгол улсын экспортын орлогын 65 хувийг БНХАУ руу хийх экспорт, үүний тал хувийг зэсийн экспорт эзэлдэг юм.

Зураг 3 Худалдааны алдагдал тогтворжиж, 2009² онтой харьцуулбал нэлээд сайжирсан


Сая \$, 12-сарын гулсмал нийлбэр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар, Монголбанк, Дэлхийн Банк

Зураг 4 Ашигт малтмалын үнийн өсөлт үргэлжилсээр байна...


Индекс=100 2007 оны 1-р сар



Эх сурвалж: Дэлхийн Банк

Зураг 5 Ерөнхий суурь сайжирч байгааг үл харгалзан БНХАУ-аас оруулж ирэх импорт өсөж байна


% өмнөх жилтэй харьцуулсан өсөлт, 3-сарын дундаж



² Худалдааны сарын мэдээлэл нь Монгол улсын цаг агаар, улиралтай холбоотойгоор өөрчлөгддөг бөгөөд сар бүрийн хэлбэлзэл бас үүнээс хамаардаг. Ийм учраас 12 сарын гулсмал нийлбэр дүнгээр үзүүлэв.

Зураг 6 ...Монгол улсын экспортыг дэмжиж байна


% өмнөх жилтэй харьцуулсан экспортод эзлэх хувь, улс улсаар үзүүлэв



Монгол улсын алтны экспорт өмнөх жилүүдтэй харьцуулбал багассан. Алтны үнэ 3-р сард унц нь 1100 ам.долларт буюу тогтвортой байсан боловч өнгөрсөн жил алт олборлогчдыг дэмжих зорилгоор засгийн газраас санхүүжүүлж олгосон зээлийг үл харгалзан 2010 оны эхний 2 сард алтны экспорт 2009 оны мөн үетэй харьцуулбал 80 хувь доогуур байсан. Өмнөх саруудын сарын тоймд дурьдаж байсанчлан алтны экспортын хэмжээ буурахад нөлөөлсөн олон хүчин зүйл байгаа бөгөөд үүнд гэнэтийн ашгийн татвар (ГАТ) байсаар байгаа мөн алт экспортлогч томоохон компаниуд алтны олборлолтыг багасгасан зэрэг орно. Инээдтэй ч гэмээр мэдээлэлд дурьдсанаар бол алтны экспортын хэмжээ өндөр байж болох боловч ГАТ-ын улмаас хүмүүс хууль бусаар алтыг хил давуулах болсон гэжээ. Мөн үүний адилаар алт олборлогчид 2011 онд ГАТ байхгүй болох хүртэл алтаа экспортлохгүй хүлээж байгаа байж болох талтай.

Зураг 7 Нүүрс, зэсийн экспорт сайн гүйцэтгэлтэй байсан


Өмнөх жилтэй харьцуулсан өсөлтөд эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар, Дэлхийн Банк

Зураг 8 Импорттой хамт өсөлт 2010 онд нэмэгдэж байна

Өмнөх жилтэй харьцуулсан өсөлтөд эзлэх хувь



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Газар, Дэлхийн Банк


3-р сард өмнөх жилтэй харьцуулсан импортын барааны доллараар илэрхийлсэн үнэ нь 47 хувиар өссөн байсан энэхүү үзүүлэлт 2009 оны эхний хагас жилд 50 гаруй хувиар багассан байсан. Энэхүү өсөлт нь ашигт малтмалын бүтээгдэхүүний импорт огцом багассантай холбоотой юм (Зураг 9). Энэ нь голдуу дизель, бензиний импорт буюу уул уурхай, барилга, хөдөө аж ахуй гэх мэт гол салбаруудын үйл ажиллагаа эхлэхтэй холбоотойгоор эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдсэнийг харуулж байна.

Ам.доллартай харьцах төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байна

2009 оны 4-р сард Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлж, валютын арилжаанд дуудлага худалдааг нэвтрүүлснээс хойш ам.доллартай харьцах төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байна. 3-р сард ам.доллартай харьцах төгрөгийн ханш 2-р сартай харьцуулбал 2.3 хувиар чангарсан байна.

Зураг 9 Валютын ханш тогтвортой байна

Төгрөг ам.доллар
хувь



Тайлбар: Зэрэгцээ зах зээлийн ханш нь худалдах, нэрлэсэн үнэ хоёр дундах цэг юм. Эерэг албан ханш нь харьцангуй буурч байгааг илтгэнэ. Нэрлэсэн-худалдах үнийг тэр хоёрын дундаж үнийг хувиар илэрхийлж хэмжсэн

Сүүлд ажигласан огноо: 2010-04-12.

Эх сурвалж: Монголын санхүүгийн холбоо, Дэлхийн Банк

Гадаад валютын ханш харьцангуй тогтвортой байгаа нь 2009 оны сүүлээр Монголбанкны гадаад валютын нөөц дээд амжилт тогтоож, 1145 сая ам.долларт хүрсэнтэй холбоотой. 11-р сараас хойш Монголбанк нь гадаад валютын худалдан авалт хийгээгүй бөгөөд 3-р сард арилжааны банкуудаас 25.9 сая ам.доллар худалдаж авсан. Гадаад валют ийнхүү өссөн нь мөнгөөр илэрхийлэгдэх алт, олон улсын санхүүгийн байгууллагуудын санхүүжилт, арилжааны банкуудын хадгаламж нэмэгдсэнтэй холбоотой. Нэг, хоёрдугаар сард бага зэрэг буурч байсан гадаад валютын нөөц 3-р сард харьцангуй нэмэгдэж, рекорд тогтоох түвшинд хүрээд байна (Зураг 11).

Инфляци


Эдийн засаг сэргэж байгаа ч инфляцийн дарамт нэмэгдэж байна

Эдийн засгийн сэргэлт, төлөв 2010 онд өсөж байгаа нь хэрэглээний үнийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулж байна. 2009 оны 4-р улирал, 2010 оны эхээр улирлын үндсэн болон УБ-ын хэрэглээний үнийн индексээс харвал үнийн өсөлт сард 2-3 хувьтай байна (Зураг 12). Эдийн засгийн сэргэлтийн үед үнийн өсөлтийн дарамт үүсч магадгүй байгаа ч энэ хандлагыг цаашид өмнөх өсөлттэй үеүүдэд ажиглагдсан хэт халалт руу хөөргөхгүй байхыг баталгаажуулах нь чухал юм.

Зураг 10 Монгол банкны гадаад валютын нөөц рекорд тогтоох түвшинд хүрээд байна

Тэрбум \$, stock
өөрчлөлт

сая ам.доллар. МБ




Тайлбар: Дөрвөлжин дотор байгаа тоо нь 3-р сард Монгол банкны гадаад валютын нөөцийн үлдэгдэл, сая ам.доллараар илэрхийлэгдсэн.

Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк

3-р сард эрчим хүч, түвшний үнэ буурсантай холбоотойгоор ХҮИ болон УБ-ын ХҮИ, инфляци харьцангуй буурсан (Зураг 13). Температур 0 хэмээс дээшлэх үед эрчим хүч, түвшний үнэ өмнөх онтой харьцуулбал 1.6 хувиар буурч, УБ-ын инфляцийн түвшин 2-р сард 8.7 хувьтай байсан бол 3-р сард 7.8 хувь болж буурсан байна. Улсын хэмжээнд ХҮИ –ын инфляци өмнөх жилтэй харьцуулбал 8.5 хувь болсон. УБ-ын индексийн үндсэн үнүүд тухайн сард харьцангуй тогтвортой байсан ба улирлын шинж чанартай хувцас, тавилгын худалдааны үнэ буурсантай холбоотойгоор 3-р сард инфляцийн түвшин 6.2 хувь болж буурсан байна.

Зураг 11 Сүүлийн хэдэн сард инфляцийн дарамт нэмэгдсэн


Инфляци, сар сараар үзүүлэв (улирлаар тооцсон), хувь



Тайлбар: Энэ нь УБ хотын ХҮИ. Улирлын тохируулга х-12 багц.
Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар, Дэлхийн Банк

Зураг 12 жилийн инфляци нэмэгдсэн

ХҮИ-ийн инфляцид оруулах хувь нэмэр, хувиар



Тайлбар: тасарсан зураас (улсын хэмжээний ХҮИ)-аас бусад нь УБ хотын ХҮИ.
Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар, Дэлхийн Банк


Банкны салбар

Арилжааны банкуудын зээл олголт өндөр хэвээр байна

Нэрлэсэн зээлийн болон хадгаламжийн хүү өндөр өндөр хэвээр байна. Гадаад валют болон төгрөгийн хадгаламжийн хүү 3-р сард тогтвортой байсан. Дундаж зээлийн хүү бага байгаа ч 20 хувьтай байна. Инфляцийн бууралттай холбоотойгоор зээлийн бодит хүү хэлбэлзэж байна (Зураг 14). Өсөлттэй холбоотойгоор инфляцийн хүлээлт нэмэгдэх учраас өмнөх хойд бодит хүү буурахаар байна. 2010 оны эцэс гэхэд ХҮИ инфлци 7.5 хувьтай байхаар таамаглаж байгаа бол өмнөх хойд хүү 10 хувьтай байхаар байна.

Зураг 13 Гэхдээ зээлийн нэрлэсэн хүү тогтвортой байна


Хувь (жилийн түвшин)



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний Статистикийн Газар, Дэлхийн Банк.

Зураг 14 Төгрөгийн хадгаламж нэмэгдэж, гадаад валютын ханш цаашид буурах хандлагатай байна

Тэрбум төгрөг, өөрчлөлт сараар тэрбум төгрөг, валют



Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк


Зээлийн өсөлт зогссон

Жилийн үзүүлэлтээр зээлийн өсөлт 3-р сард зогсонги байдалтай байсан (Зураг16). Нийт төлөгдөөгүй зээл 4 дэх сардаа тогтмол хэвээр байсан. Хувийн хэвшилд олгох зээлийн өсөлт эерэг үзүүлэлттэй байгаа ч жилийн өсөлт 3-р сард 3.1 хувьтай байсан нь өнгөрсөн жилийн сүүлээр харагдсан өсөлтийн дөнгөж тал хувьтай тэнцүү байна. 3-р сарын мэдээнээс харвал банкууд эрсдэл багатай төв банкны үнэт цаасыг худалдаж авсаар байгаа ч энэ нь сүүлийн хэдэн сарын худалдан авалтаас хурд нь саарсан байдалтай байна.

Зээлийн бодит хүү болон төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт өндөр байгаа нь төгрөгийн хадгаламжийг нэмэгдүүлсээр байна (Зураг 15). Үнэн хэрэгтээ төгрөгийн хадгаламж 2-р сартай харьцуулбал 3-р сард өсөж 1374 тэрбум төгрөг болсон байна. Гадаад валютын хадгаламж хэдийгээр өндөр буюу нийт хадгаламжийн 1/3 хувийг эзэлж байгаа ч өнгөрсөн 12-р сарын эцэст 622 тэрбум хүрч байсантай харьцуулбал 3-р сард 551 тэрбум болж 3 дэх сардаа буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 15 Нийт зээл олголтын өсөлт тогтмол байгаа ч Төв банкны үнэт цаасны худалдан авалт нэмэгдэж байна


Өөрчлөлт, жилээр, %



Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк.

Зураг 16 Чанаргүй зээлийн харьцаа 20 хувиас дээш үзүүлэлттэй байна

Тэрбум төгрөг



Тайлбар: Дөрвөлжин дотор байгаа тоонууд нь төлөгдөөгүй нийт зээлд эзлэх оршин суугчид болон оршин суугч бус этгээдэд олгосон чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн үндсэн зээл

Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын шинэчлэл тулгамдсан асуудал болоод байна

Өнгөрсөн жил хоёр томоохон банк дампуурч, төлбөрийн чадваргүй болсон нь банкны салбарыг сулруулсан. Энэ хугацаанд хувийн хэвшилд олгох зээлийн тоо буурсан. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн үндсэн зээл нь нийт төлөгдөөгүй зээлийн 21.5 хувийг эзэлж байна. Дампуурсан 2 банкныг оруулалгүйгээр, 2010 оны 3-р сарын эцэст нийт төлөгдөөгүй зээлд эзлэх чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн үндсэн зээлийн хэмжээ 14.5 хувь байсан (Зураг 17).

Гэвч өнгөрсөн жил өсөж байсан чанаргүй зээл 12-р сард 462 тэрбум байсан бол 3-р сард буурч ойролцоогоор 416 тэрбумд хүрсэн нь чанаргүй зээл буурч байгааг харуулж байна. Гэтэл үндсэн зээлийн өр³ 12-р сараас хойш 23 хувиар өсөж 3-р сард 149 тэрбум төгрөгт хүрсэн. 2009 онд нийтдээ⁴ 143.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан арилжааны банкууд 3-р сард 2.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Монгол банк олон улсын туршлагаадаас (үүнд Хайрцаг 3-т үзүүлсэн Швед, Тайланд, Туркын банкны салбарын хямралаас гарсан туршлагыг тоймлов) тусгасан банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг саяхан боловсруулсан. Энэхүү төслийн талаар банкууд болон

³Эдгээр зээл нь үндсэн зээлийн төлбөрийг 1-90 хоноогоор хугацаа хэтрүүлсэн зээл юм. 90 хоногийн дараа тэдгээрийг чанаргүй зээлийн ангилалд оруулдаг.

⁴ Зээлийн нэгдсэн тайлан, 2010 оны 3-р сар, Монголбанк

УИХ-ын гишүүд зэрэг оролцогч талуудтай ярилцсан. УИХ энэхүү төлөвлөгөөг цаг алдалгүй батлах нь чухал үүрэгтэй байх болно.

Монгол Улсыг бүтцийн өөрчлөлт болон засгийн газрын дэмжлэгтэй холбогдон гаргах эдийн засгийн болон төсвийн зардлыг хязгаарлах олон улсын шилдэг туршлагад нийцүүлсэн арга хэмжээ авахад чухал үүрэг гүйцэтгэх болно. Санал болгож байгаа бүтцийн өөрчлөлтийн стратеги нь 3 зарчимд үндэслэсэн. Нэгдүгээрт, банкны тухай хууль дүрэм, журмыг сахиулах зорилгодоо нийцсэн, зохих хувийн эзэдтэй, менежерүүд бүхий хөрөнгө сайтай банкуудтай байх. Банкны салбар сул талаа дөнгөж далдлах төдий байна. Хоёрдугаарт, хэрэв эздүүд нь зохистой харьцааг хангахад шаардлагатай хөрөнгийг хуримтлуулж чадахгүй бол, төсвийн хөрөнгийг банкуудыг дэмжих зорилгоор хамгийн эцсийн нөхцөл болгож, хатуу шаардлагын дор зарцуулах болно. Эцэст нь дахин хөрөнгөжүүлэх ажлыг зорилгодоо хүрэх, дүрмийг хэрэгжүүлэх явцад ил тод байлгах, мөн банкуудад шударгаар тэгш хандах зорилготой.

Хайрцаг 3 БНТурк улс: 2000/2001 оны хямралын дараахь банкны салбарын шинэчлэл

Банкны салбарын хямралын үүсэл, нөлөө

1999 оны 12-р сард Туркийн банкны салбарт банкны төлбөр тооцоо клирингийн асуудалтай холбоотойгоор хүндрэл гарч эхэлсэн. Банкны системд банкны туршлага бага, зохицуулалт муу, компанийн засаглал дутагдалтай явдал түгээмэл байсан. Хувийн банкууд олон нийтэд арилжаа хийдэггүй, зөвхөн өөрсдийн компани группийн хэмжээнд үйлчилдэг байсан. Хувийн банкууд нь улс төрийн намуудад харьяалагддаг байсан бөгөөд улс төрийн сонгуулийн тойргуудад татаас зээл олгож, банкны алдагдлыг засгийн газар хариуцаж байсан. Хуримтлагдсан алдагдал нь эдгээр банкуудыг хөрвөх чадваргүй болгож, зээлийн хүүний цочролд оруулсан. 1999 оны 12-р сар гэхэд Засгийн газар Туркийн 5 банкинд хямралаас гарах туслалцааг үзүүлсэн байсан.

Засгийн газар, Төв банкны авах арга хэмжээ дэндүү удаан, бас үр дүнгүй байсан. 2000 оны 12-р сар гэхэд дахин 3 банкинд хямралаас гарахад нь туслалцаа үзүүлсэн. Зээлийн гэрээнд зээл эргэн төлөгдөхгүй байх, давагдашгүй хүчин зүйл гэсэн заалтууд идэвхтэй орж, хэрэгжих аюулууд тулгарсан. Засгийн газраас үр дүнгүй алхмууд хийсний дараа 2001 оны нэг/хоёрдугаар сард илүү том хямрал нүүрлэсэн. Мөнгөний ханш унаж, банкууд хөрвөх чадваргүй болж эхэлсэн. Энэ үед банкууд гадаадын зээлдэгчдэд (балансын бус тэнцэлийг оруулахгүйгээр) 16 сая ам.долларын өртэй болсон. Засгийн газар дахин хоёр банкинд интервенц хийхээс өөр аргагүй болсон.

Салбарын хэмжээнд бүрэн хямралд орж, суурь капитал бүхэлдээ идэгдэж, банкны хөрвөх чадвар үгүй болж, иргэдийн итгэлийг алдсанаас хадгаламж багасч, цаашид банк дамдуурахад хүрч байсан. Хямрал системийн хэмжээнд гарч, хямралаас гарах асуудлыг шийдэхэд дэндүү үнэтэй болсон. Гэвч, Засгийн газраас авах арга хэмжээ дэндүү удаан, улс төрийн тавцан ганхаж байсан учраас эвслийн засгийн газар 3 намаас бүрдэж байгуулагдсан.

Бүтцийн өөрчлөлт хийх стратеги

Энэхүү үзэгдэлтэй тулсан засгийн газар болон төв банк нь эцэстээ Банкны бүтцийн өөрчлөлтийн цогц хөтөлбөр (ББӨЦХ)-ийг хэрэгжүүлэхээр шийдсэн. ББӨЦХ-ийн дөрвөн гол тулгуур нь: i) төрийн банкуудад бүтцийн өөрчлөлт хийх; ii) асуудалтай байгаа банкуудыг Хадгаламжийг даатгах сангаар дамжуулан авч, бүтцийн өөрчлөлт хийх; ба iii) зохицуулах, хянах хууль журмыг бэхжүүлж дахин капиталжуулах хөтөлбөртэй хамт хэрэгжүүлэх яюдал байсан.

Төрийн банкнуудын нийт хуримтлагдсан алдагдал 26 сая ам.доллартай тэнцүү байсан. Хөрвөх чадвартай байхын тулд нэг өдрийн зээл нь 14 сая ам.долларт хүрсэн байсан. Банкууд өөрсдөө бүтцийн өөрчлөлт хийж, хувиарлах суваг, маркетинг, борлуулалт, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага гэсэн чиглэлүүдээр өөрчлөлт хийсэн. Үйл ажиллагааг сайжруулах, олон нийттэй харилцах зорилгоор засгийн газраас зөвлөх, шинжээчдийг томилж байсан. Хувьчлах төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Хадгаламжийг даатгах сан (ХДС) асуудалтай банкуудыг худалдан авсан. ХДС-нд бүтцийн өөрчлөлт хийхийн тулд бэлэн 14 сая ам.доллар хэрэгтэй байсан. Зардлыг багасгахын тулд хувийн банкууд түргэн худалдагдаж байсан буюу нэгдэж байсан. Ерөнхийдөө банкны зардлын 27.7 тэрбум ам.долларыг ХДС-д шилжүүлж, үүний 11.8 тэрбум буюу 42 хувийг хувьцаа эзэмшигчдээс цуглуулсан байна.

Үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд Банкны бүтцийн өөрчлөлт хийх тухай шинэ хуулийг баталж, банкны дампуурлын тухай хуулинд өөрчлөлт оруулсан. Хууль эрх зүйн орчныг сайжруулж, шинээр болон сайжруулсан журмуудыг гаргасан. Үүнд: капиталын шаардлагыг хангах, эрсдэлийн удирдлага, зээллэгийн хязгаар, зээлийн эрсдэлийн сан, хамааралтай этгээд, нягтлан бодох бүртгэлийн стандарт болон хөндлөнгийн аудит хийхтэй холбоотой журмууд орно.

Өрийг солилцох ажил (Засгийн газрын бондын эсрэг 7.5 тэрбум доллар) хийж, дахин капиталжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүнээс харахад банкны бүтцийн өөрчлөлт нь банкны салбарыг нэгтгэж, төр, ХДС-ийн хувь оролцоог бууруулж, санхүүгийн эрсдэлийг багасгаж, ил тод байдал, ашиг орлогыг нэмэгдүүлж, капиталын бүтцийг бэхжүүлж, зээл болон гадаад санхүүжилтийг нэмэгдүүлсэн байна. Арван дөрвөн банк (үүнд системийн нэг банк орно) нь гурван банкинд нэгдсэн. 1999 онд Турк улсад 81 банк ажиллаж байсан бол 2010 оны байдлаар 45 банк ажиллаж байна. Туркийн банкны капитал 2001 онд 1.4 тэрбум ам.доллар байсан бол одоо 73.4 тэрбум ам.доллар болсон байна.

Суралцсан зүйл

- Бүтцийн өөрчлөлт хийх стратегийг эртхэн хэрэгжүүлсэн бол зардал бага байх байсан. Банкуудад хатуу интервенц хийх бодлогыг барих нь банкны бүтцийн өөрчлөлт хийх зардлыг бага байлгана.
- Хуулийн эрсдэлийг эрт тооцож үзэх ёстой. Тухайлбал: эд хөрөнгийг худалдахад хуулийн ямар нэг бэрхшээл байх ёсгүй. Урьдчилан таамаглаж, хэрэгжүүлж болохуйц хуулийн системтэй байх нь зардлыг бага байлгахад тустай. Мөн засгийн газар болон бусад сонирхогч талуудын оролцоог бага байлгана.
- Хяналтын хүчтэй бүтэцтэй байх нь чухал. Газар дээрх болон зайны хяналт хийхийн тулд нягт хамтын ажиллагаа хэрэгтэй. Луйвар, буруу тайлагналтыг илрүүлэхийн тулд гадны шинжээчдийг авч ажиллуулах нь чухал байдаг.
- Олон нийтэд мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх чухал үүрэгтэй байдаг. Учир нь олон нийтэд мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх нь санхүүгийн системийн итгэлийг хадгалахад чухал үүрэгтэй.

Эх сурвалж: BRSA болон ХДС-ийн тайлан, УБ хотод банкны чиглэлээр семинар явуулах үед Engine Аксакоса-ийн презентаци дээр үндэслэн гаргасан Дэлхийн банкны мэдээлэл

Хөдөлмөрийн зах зээл, ядуурал


Ажиллах хүчний судалгаагаар ажилгүйдэл 13 хувьд хүрсэн байна

Хөдөлмөр нийгмийн хангамжийн үйлчилгээний төвүүдэд албан ёсны бүртгэлтэй ажилгүйдлийн түвшин 2009 оны 7-р сараас эхлэн буурч 3-р сард 3.3 хувьд хүрсэн (Зураг 18). 2009 оны 3-р сард бага зэрэг өсөж 3.2 хувьд хүрч байсан. Нийт бүртгэлтэй ажилгүйдлийн тоо өсөж, 2008 оны 12-р сард байсан ажилгүйдлийн тоотой харьцуулбал 1/3-ээр өссөн байна.

Гэвч өмнөх сарын тоймд өгүүлж байсанчлан ажилгүйдэл, цалингийн түвшинд эдийн засгийн хямрал хэрхэн нөлөө үзүүлж байгааг дутуу тооцсон байж болох талтай. Дөрөвдүгээр улирлын ажиллах хүчний судалгаагаар буюу Хөдөлмөр, нийгмийн халамжийн төвүүдэд бүртгэлтгүй хүмүүсийг оруулж тооцсоноор ажилгүйдэл 12.8 хувьтай байсан ба энэ нь 2009 оны 9-р сараас хойш 10.5 хувиар өссөнийг харуулж байна. Мөн энэ нь нийт 1120 мянган ажиллах хүчнээс 142000 хүн ажилгүй байна гэсэн үг юм.

Зураг 17 Сүүлийн саруудад албан ёсны бүртгэлтэй ажилгүйдлийн* тоо буурч байна

Тэрбум төгрөг, өөрчлөлт сараар,



Тайлбар: * ажиллах насны хүн ам бөгөөд цалинтай ажил хийгээгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, ажил идэвхтэй хайж байгаа, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй хүмүүсийг хэлнэ.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар, Дэлхийн Банк

Хөдөөгийн ядуурал, зудын үр нөлөө

Саяхан болсон зуданд Монгол орны нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь автаж, 175 сум, 98000 малчид өртсөн байна. Хүнс, Хөдөө аж ахуйн яамны хамгийн сүүлийн үеийн мэдээллээс үзвэл зуднаас болж зүй бусаар хорогдсон малын тоо 6.9 саяд хүрч нийт малын 15.6 хувийг эзэлж байна. Малын дундаж үнээр тооцож үзвэл зөвхөн өнгөрсөн өвөл 360.3 сая төгрөгийн алдагдал гарсан байна. Зудын гамшгаас гарахад зориулж олон улсын байгууллагууд тусламж үзүүлж байгаа бөгөөд Дэлхийн банк гэхэд 11.9 сая ам.долларын тусалцаа үзүүлж монгол улсын засгийн газар өнөөдрийг хүртэл 26.2 тэрбум төгрөгийг тараах боломжтой болсон.

Хайрцаг 4 Малчдад олгосон зээл чанартай зээл

Малчид зуданд өртөхөөр банкны салбарт ямар үр нөлөө үзүүлж болох вэ? Энэхүү хайрцагт малчдад зээл олгогч томоохон зээлдүүлэгч ХААН банкнаас авсан мэдээллийг ашиглан малчдад олгосон зээлийн шинж чанар, энэхүү асуудлыг авч үзэх болно.

Монгол улсад нийт 171,000 малчин айл өрх байдгийн 66000 (39 хувь) нь Хаан банкнаас зээл авсан ба 60 сая төгрөгийн төлөгдөөгүй зээл байна. Малчдад олгосон зээл нь тус банкны нийт зээлийн багцийн 9.7 хувийг эзэлж байна. Малчдад олгосон зээл нь бусад зээлүүдтэй адил сар болгон эргэн төлөлттэй байдаггүй зээлийн тусгай бүтээгдэхүүн юм. Учир нь энэхүү зээл нь малчдыг

хэрэглээ болон арилжааны хэрэгцээнд нийцүүлэхэд туслах зорилгоор жилд хоёр удаа эргэн төлөхийг шаарддаг: i) 5-6-р сар буюу ноолуурын улирал эхэлж малчид орлоготой болсон үед төлөх, ба ii) 9-11-р сар буюу мал нядлах цагаар орлогоос төлөх боломжийг олгодог юм. Зээлийн хугацаа 9-12 сар байдаг ба нэг малчинд олгох зээл дунджаар 917,000 төгрөг байдаг. –аас дээш толгой малтай малчид энэхүү зээлийг авах эрхтэй байдаг. Малчдын зээлийг хэрэглээ, барааны хөрөнгө оруулалт, боловсролын зардал гэх мэт зүйлд ашигладаг ба зээлдэгчдийн 77 хувь нь нарны зайн эх үүсгүүр, автомашин, цахилгаан хэрэгсэл, өвс, тэжээл эсвэл хүүхдийн сургуулийн төлбөр төлөхөд зарцуулсан байна.

Эргэн төлөлтийн тусгай нөхцлүүдийг үл харгалзан, малчдын зээл нь банкны хувьд найдвартай зээлд тооцогдох болсон. Малчдад олгосон зээлийн 95.3 хувь нь цагтаа эргэн төлж байгаа (2010 оны 3-р сарын 31-ны байдлаар малчдын хугацаа хэтэрсэн зээл нийт төлөгдөөгүй зээлийн 4.3 хувийг эзэлж байсан) юм. Малчдад олгосон зээлийн ихэнхийг 2009 онд ноолуурын үнэ кг нь 23-28 мянган төгрөгт хэлбэлзэж байх үед олгосон. Гэвч одоо ноолуур кг нь 54 мянган төгрөг болсон байгаа нь эргэн төлөлтөд тусалж байна.

Малчдын зээл хугацаа хэтрэхэд нөлөөлөх гурван шалтгаан байна гэж үзэж байна. Нэгдүгээрт хугацаа хэтэрсэн зээлийн 23.6 хувь нь хаан банкны байрлаж байгаа сумын төв орж чадахгүй, холбоо барьж чадахгүй байсантай холбоотой. Хоёрдугаарт хугацаа хэтэрсэн зээлийн 28 хувь нь малын худалдаа, эсвэл малын арьс, шир гэх мэт түүхий эд, материалын борлуулалтаас орж ирэх ёстой байсан бэлэн мөнгө орж ирээгүйгээс болсон. Гуравдугаарт 15.6 хувь нь малын хорогдлоос болсон.

Зудын үр нөлөө ямар байх вэ? ХААН банкны тооцоолж байгаагаар зудны үр нөлөөгөөр зээлийн чанар муудаж магадгүй гэж үзээд зээлийн эргэн төлөлтийг хэвийн байлгахын тулд дараахь арга хэмжээнүүдийг авч байна:

- Хураамжаас 100 хувь чөлөөлж, зээлийн хугацааг сунгаж байна. Ойролцоогоор 21,700 малчид энэхүү арга хэмжээнд хамрагдаж, 96 хувь нь цагтаа эргэн төлж, 300 сая гаруй төгрөгийн хураамжаас чөлөөлсөн.
- Зээлийн хугацааг хоёрдахь удаа сунгаж, цаашид олох орлогоос эргэн төлөх уян хатан бодлого барьж байна. Энэхүү арга хэмжээнд нийт зээлдэгчдийн 1.4 хувь буюу 951 малчин хамрагдсан байна.
- Бүх малаа алдсан алдсан малчдад торгуулийн хүүг чөлөөлөх, зөвхөн үндсэн зээлээ төлөх саналыг тавих зэрэг хөнгөлөлттэй нөхцлүүдийг санал болгосон.

Эдгээр арга хэмжээнүүдээс гадна банк 2010 оны 6-р сарын 30-ныг хүртэл зээлийн эрсдэлийн санг 10 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээ авсан.

Тайлбар: Мэдээллийг ХААН банкнаас авав.

УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэх шинэчлэлүүд

Одоогоор Монгол Улсын Парламент хэд хэдэн чухал шинэчлэлүүдийг хэлэлцэж байгаа бөгөөд үүнд одоо байгаа нийгмийн халамжийн тэтгэмжүүдийг нэгтгэж, сайжруулах, төсвийн тогтвортой байдлаар шийдэхийн тулд нийгмийн халамжийн цогц шинэчлэл орж байна. Мөн УИХ нь Төсвийн тогтвортой байдлын тухай болон Нэгдсэн төсвийн тухай хуулиудын төслийг хэлэлцэж уул уурхайн орлогл (ОТ төслийн улмаас урт хугацааны өсөлт болон өөрчлөлтийн хувьд)-ыг зөв удирдах болон тууштай төсвийн бодлогын хүрээг тавих болно.

Банкны салбарын хувьд банкны салбарын ажиллагааг сайжруулах, банкны асуудлуудыг цаг хугацаанд нь зардлын үр ашигтайгаар шийдвэрлэх арга зам, механизмуудыг гаргаж хэрэгжүүлэх зорилгоор бүтцийн өөрчлөлт хийх стратегиудын

төслийг гаргаж УИХ-д өргөн барьсан. Төв банкны интервенц хийх эрх мэдэл, хоригийг бэхжүүлэх замаар банкны засаглалыг сайжруулахын тулд Банкны тухай хуульд 1-р сард өөрчлөлт оруулсан.

Эдгээр шинэчлэлүүд нь Монгол Улсыг гэнэтийн өсөлт-бууралтын мөчлөгөөс сэргийлэхэд тусалж, цаашдын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих болно. Санхүүгийн салбарын одоогийн тулгамдаад байгаа асуудлыг шийдвэртэйгээр, ил тод байдлаар шийдвэрлэх нь тухайн салбарыг цаашид гарах эдийн засгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, капиталын урсгалын өсөлт бууралтад бэлтгэлтэй байхад тусална.

Эцэст нь УИХ-ын хаврын чуулганы үзэр 2010 оны төсөвт тодотгол хийхээр байна. Төсвийн хөрөнгө оруулалтын хэсэг буюу ихэнх нь техник эдийн засгийн үндэслэл байхгүй, сонгуулийн тойргуудад хуваарилах 76 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төслүүдэд Монгол улсын ерөнхийлөгч хориг тавьсан боловч 2009 оны 11-р сард 2010 оны төсвийн тухайн хуулийг УИХ-аар баталсан. Монгол улсын үндэсний аудитын газраас явуулсан аудитаар энэ нь батлагдсан бөгөөд энэхүү хаврын чуулганы үеэр төсөвт тодотгол хийж тэдгээр төслүүдийг хасуулах дарамт үүсэж болохоор байна. Хамгийн чухал нь төсвийн тодотгол хийхдээ өмнөх мөчлөгүүдийн алдаанаас суралцаж, хүлээлтээс илүү олсон орлогыг зарлага болгож болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй байна. Өмнөх туршлагаадаас харахад ийнхүү орлогыг зарлага болгон гаргах нь инфляцийг хөөрөгдөж байсан ба ОТ-г ашиглалтад оруулахаас өмнөх жилүүдийг улам хүнд болгох аюултай.

Хүснэгт 2 Монгол улс: Гол үзүүлэлтүүд

	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Үйлдвэрлэлт, ажил эрхлэлт, үнэ							
ДНБ-ний бодит өсөлт (өомүх өөрчлөлт%)	7	10.6	7.3	8.6	10.2	8.9	-1.6
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний индекс (өомүх өөрчлөлт%)	100	110.4	113.4	109.6
Ажилгүйдэл (%)	3.4	3.6	3.3	3.2	2.8	2.8	3.3
Хэрэглээний үнийн индцкс өомүх өөрчлөлт%)	4.6	10.9	9.6	5.9	14.1	23.2	1.9
Улсын салбар							
Төсвийн тэнцэл (ДНБ-ний %)	-3.7	-1.8	2.6	3.3	2.8	-5	-5.4
Уул уурхайн бус тэнцэл (ДНБ-ний %)(1)	-5.9	-5.8	-1.3	-7.3	-13.4	-15.1	-12.9
Улсын салбарын дотоод өр (ДНБ-ний %)	3.1	1.4	0.1	1	0.5	0	6.3
Гадаад худалдаа, гадаад худалдааны тэнцэл, гадаад өр(2)							
Худалдааны тэнцэл (сая ам.доллар)	-199.6	-99.2	-99.5	136.2	-52.4	-612.6	-157.9
Барааны экспорт (сая ам.доллар)	627.3	872.1	1066.1	1542.8	1889	2539.3	1902.6
(өомүх өөрчлөлт%)	19.7	39	22.2	44.8	22.4	34.4	-25.1
Зэсийн экспорт (өомүх өөрчлөлт%)	14.7	94.8	27.7	12.1	39.9
Барааны импорт (сая ам.доллар)	826.9	971.3	1021.1	1485.6	2117.3	3615.8	2131.3
(өомүх өөрчлөлт%)	21.6	17.5	16	25.4	42.5	70.8	-41.1
Урсгал дансны тэнцэл (сая ам.доллар)	-102.4	24.1	29.7	221.6	264.8	-721.9	-235.1
(ДНБ-ний %)	-7.1	1.3	1.3	7	6.7	-13.9	-5.6
Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)	131.5	128.9	257.6	289.6	360	836	426
Гадаад өр (ДНБ-ний %)	92.6	76	61.2	45.1	40.1	34.6	50
Үүнээс улсын болон засгийн газрын баталгаатай (ДНБ-ний %)	87.3	73.7	59.7	44.3	38.9	33.7	47.1
Үүнээс хувийн сектор (ДНБ-ний %)	5.4	2.4	1.5	0.7	1.2	0.8	2.9
Өрийн үйлчилгээний харьцаа (бараа үйлчилгээний экспортын %)(3)	35.1	7.5	2.7	2.3	2	2	3.7
Гадаад валютын нөөц,нийт (сая ам.доллар)	203.5	207.8	333.1	718	1000.6	656.9	1327
(бараа, үйлчилгээний импортын сараар)	2.4	2	2.6	4.3	3.8	3	4.9
Санхүүгийн Зах зээл							
Дотоодын зээл (% жилийн өөрчлөлт)	157.3	25.8	18.8	-3.1	78.4	52.5	-7.5
Богино хугацааны зэлийн хүү (жилийн %)(4)	..	15.8	3.7	5.1	8.4	9.8	..
Валютын ханш (төгрөг/ам.доллар, хугацааны эцэст)	1168	1209	1221	1165	1170	1267.5	1442.8
Үйлчилж буй бодит ханш (2006=100)(5)	94.2	93.9	99.6	102.8	104.8	127.4	102.9
(өомүх өөрчлөлт%)	-4.8	-0.4	6.1	3.2	1.9	21.5	-19.2
Хөрөнгийн захын индекс (2000=100)(6)	151.5	120.8	203.6	382	2048	1181.6	..
жич:							
ДНБ оны үнээр (тэрбум төгрөг)	1660	2152	2780	3715	4600	6020	6055
ДНБ оны үнээр (сая ам.доллар)	1448	1814	2307	3156	3930	5258	4.203
Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)	583	722	900	1214	1491	1980	1600

Тайлбар: (1) уул уурхайн бус орлогод уул уурхайн компаниудын аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ногдол ашгийн төлбөр, гэнэтийн ашгийн татвар, нөөц ашигласны төлбөрүүд багтаагүй (2) Төлбөрийн тэнцлийн 2008 оны мэдээ нь хамгийн сүүлийн хувилбарт үндэслэсэн (3) улсын болон баталгаатай өр (4) 2006 оныг хүртэлх 14 хоногийн үнэт цаасны өгөөж, 2007 оны 7 хоногийн үнэт цаасны өгөөж (5) өсөлт нь ханш чангаралтыг илэрхийлнэ (6) ТОП-20 индекс, жилийн эцэст, 2000 оны 12-р сард индекс=100.

Эх сурвалж: Монголбанк, Үндэсний Статистикийн Газар, Сангийн Яам, ОУВС, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо, судлагаа